



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 133


Улаанбаатар
хот

Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх авто
замын төслийн санхүүжилтийн талаар
авах арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.20, 9.1.21-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор баталсан “БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалт”-ын 4-т заасан “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих төсөл”-д нэмж шаардагдах 1.2 (нэг сая хоёр зуун мянга) сая ам.доллар, 10-т заасан “Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн Загастайн давааны 67 км авто зам барих төсөл”-ийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардалд шаардагдах хөрөнгийг уг хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн хэмнэсэн хэсгээс шийдвэрлэх талаар хятадын талтай хэлэлцээ хийж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн тохиолдолд авто замын барилгын ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдийг хятадын талаас санал болгосон компаниудаас сонгон шалгаруулж, авто замыг хугацаанд нь чанартай барьж, ашиглалтад оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ч.ХҮРЭЛБААТАР

Ж.БАТ-ЭРДЭНЭ